



Орхон аймгийн эрүүл мэндийн газар
Нийгмийн эрүүл мэндийн төв

2022 ОНЫ ОСОЛ ГЭМТЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ




Орхон аймаг
2023 он

2023 он


Мэдээ нэгтгэн бэлтгэсэн: НБТЧОГТХМ Б.Отгон-Эрдэнэ

ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ 2022 ОНЫ БАЙДЛААР

Орхон аймгийн хэмжээнд 2022 оны байдлаар гэмтэл хордлого гадны шалтгаант 797 шинэ тохиолдол бүртгэгдэж, 99 тохиолдол нас барсан байна. Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралт сүүлийн жилүүдтэй харьцуулахад өсөж буй үзүүлэлт ажиглагдаж байгаа ба тухайлбал осол гэмтлийн шалтгаант өвчлөл өмнөх оны мөн үеэс 2.6%-иар, нас баралт 4.2%-иар тус тус өссөн байна.



Нийт тохиолдлын 91.8% нь санамсаргүй байдлаар осол гэмтэлд өртсөн бол 8.2%-ийг санаатайгаар үйлдэгдсэн осол гэмтэл эзэлж байна.




Бүртгэгдсэн нийт тохиолдлыг хүйсээр авч үзвэл 555 нь эрэгтэй, 242 нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд энэ хугацаанд осол гэмтэлд өртсөн 10 хүн тутмын 7 нь эрэгтэйчүүд байна.

Эрэгтэй




Эмэгтэй





Эрэгтэйчүүдийн гэмтлийн шалтгаанд бүх төрлийн уналт (25.8%), зам тээврийн осол (14.6%) орж байна. Эмэгтэйчүүдийн гэмтлийн шалтгаанд мөн адил уналт (13.5%), зам тээврийн осол (5.3%) орж байна.




Эмэгтэйчүүдийн гэмтлийн шалтгаан




Орхон аймгийн хэмжээнд осол гэмтэл бүртгэгдсэн тохиолдлыг хугацаагаар нь авч үзэхэд зуны улиралд буюу 6, 7, 8 саруудад болон Баасан гарагт хамгийн их бүртгэгдсэн байна.



Осол гэмтлийн шалтгаант өвчлөлийн хамгийн их хувийг 30-34 насныхан эзэлж байна. Харин 65-69 насанд бусад насны бүлэгтэй харьцуулахад тохиолдлын тоо бага байна.



Гудамж зам талбайд байхдаа осол гэмтэлд өртөх тохиолдол хамгийн өндөр хувийг 33.1% /241/ эзэлдэг бол хоёрдугаарт 30.2%-аар гэртээ осол гэмтэлд өртөх тохиолдол орж байна.



ОСОЛ ГЭМТЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

Орхон аймгийн хэмжээнд 2022 онд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант өвчлөлийг уналтын шалтгаан 44.2%-р тэргүүлж байгаа бол 2-рт зам тээврийн осол 22.3%, 3-рт амьгүй механик хүчинд өртөх гэмтэл 14.5%, 4-рт хүчирхийлэл 7.6%, 5-рт түлэгдэлт 5.4%-ийг эзэлсэн байна.




Осол гэмтлийн шалтгаан тус бүрийг өмнөх онтой харьцуулан судлахад бүх төрлийн уналт, амьтай механик хүчинд өртөх, түлэгдэлт, хүчирхийлэл зэрэг шалтгаанууд өссөн үзүүлэлттэй байсан бол зам тээврийн осол /10.1%/ амьгүй механик хүчинд өртөх осол гэмтэл нь өмнөх оны мөн үеэс 23.9%-р буурсан үзүүлэлттэй байна. Осол гэмтлийн шалтгаан тус бүрд тохиолдлын тоо болон өссөн буурсан хувийг дараах хүснэгтээс харна уу.

Осол гэмтлийн шалтгаан	2021 (n=777)	2022 (n=797)	Өсөлтийн хувь
	Бодит тоогоор		
Санамсаргүй осол гэмтэл			
Зам тээврийн осол	196	178	-10.1
Бүх төрлийн уналт	322	353	8.7


Амьгүй механик хүчинд өртөх	150	116	-23.9
Амьтай механик хүчинд өртөх	19	33	42.4
Усанд живэлт	0	0	0
Амьсгал боогдох	1	0	-100
Түлэгдэлт	36	43	16.3
Хорт амьтан, ургамалд өртөх	1	1	
Санаатайгаар үйлдсэн осол гэмтэл			
Хүчирхийлэл	52	61	14.7
Амиа хорлох	0	4	

2022 оны байдлаар осол гэмтлийн улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан нийт тохиолдлын 9.7% /77/ нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол гэмтэлд өртсөн байна. Энэ нь өмнөх оны нийт осол гэмтэлд эзлэх хувьтай харьцуулахад 2%-р буурч тохиолдлын тоогоор согтууруулах ундаа хэрэглэсэн байдал өмнөх оны мөн үеэс 15.4%-иар буурсан байна. Өөрөөр хэлбэл сард дунджаар 6 хүн согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол гэмтэлд өртөж байна.




ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ


2022 оны байдлаар гэмтэл, хордлого, гадны шалтгаант 99 нас баралт бүртгэгдсэн ба энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 тохиолдлоор өссөн байна. Сард дунджаар 8 иргэн осол гэмтлийн улмаас амь насаа алдаж байна.




Гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралтын 70 /70.8%/ нь санамсаргүй осол гэмтэлд өртсөн бол 27 /27.2%/ нь санаатайгаар амиа хорлох, санаатайгаар бусдад халдах буюу хүчирхийллийн улмаас амь насаа алдсан байна. Харин осол гэмтлийн улмаас амь насаа алдсан нийт тохиолдлын 2 /2%/ нь сэдэл тодорхойгүй байна.



Осол гэмтлийн шалтгаант нас баралт, хүйсээр



Осол гэмтлийн улмаас амь насаа алдсан нийт тохиолдлын 77 /77.8%/ нь буюу 10 тохиолдол тутмын 8 нь эрэгтэйчүүд байна.



Гэмтэл, хордлого, гадны шалтгаанаар нас барсан нийт тохиолдлыг санамсаргүй хордох, хорт бодист /эмийн болон эмийн бус бодис/ өртөх тохиолдол 43 /43.4%/-р тэргүүлж байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 0.3%-аар өссөн байна. Тэргүүлэх шалтгааны 2-рт амиа хорлолт 19.1%, Уналт 8.08%, Хүчирхийлэл 8.08%, зам тээврийн осол 5.05%-р нас баралтын тэргүүлэх 5 шалтгаанд багтаж байна.

Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан



Шалтгаан тус бүрээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад зам тээврийн осол 44.4%-иар уналтын шалтгаант нас баралт 20%-иар, мөн усанд живэлт, амьсгал боогдох, түлэгдэлт, хордолтын шалтгаант нас баралтууд тус тус буурсан үзүүлэлттэй байна. Харин хүчирхийллийн шалтгаант нас баралт 60%-иар, байгалийн хүчинд өртөх 133%-иар, амиа хорлолт 58.3%-иар бүгд өссөн үзүүлэлттэй байгаа нь анхаарал татахуйц байна. Шалтгаан тус бүрээр бодит тоо болон өсөлтийн хувийг дараах хүснэгтээс харна уу.

Осол гэмтлийн шалтгаан	2021 эхний 11 сар	2022 эхний 11 сар	Өсөлтийн хувь
Бодит тоо			
Зам тээврийн осол	9	5	-44.4%
Уналт	10	8	-20.0%
Амьгүй механик хүчинд өртөх	1	1	0.0%
Усанд живэлт	3	2	-33.3%
Амьсгал боогдох	5	2	-60.0%
Түлэгдэлт	3	0	-100.0%
Хордолт	41	37	-9.8%
Байгалийн хүчинд өртөх	3	7	133.0%
Амиа хорлолт	12	19	58.3%
Хүчирхийлэл	5	8	60.0%
Тодорхойгүй	1	2	100.0%

Гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралтыг насны бүлгээр авч үзэхэд 2022 оны байдлаар 50-54 насанд нас баралт хамгийн өндөр үзүүлэлтийг эзэлж байна.

